

ИСТОРИЯ HISTORY

Эрдэм шинжилгээний өгүүлэл
УДК 82.09 (517.3)
DOI 10.18101/2949-1657-2024-4-77-86

XXI зууны эхэн үеийн монгол улсын утга зохиолын шүүмжлэлийн судалгаа

© Булган Урангоо

Өвөр Монголын их сургуулийн
Монгол судлалын дээд сургуулийн докторант
Хятад, Хөх хот, БНХАУ
urangoo1902@gmail.com

Товч агуулга. Тус өгүүлэлд XXI зууны эхэн үе буюу 2001-2021 оны утга зохиолын судлал, шүүмжлэлийн талаар өгүүлжээ. Чингэхдээ монголын утга зохиолын шүүмжлэлийн түүх, түүний туурвил зүйн онцлог, бичлэгийн төрөл хэлбэрүүд төлөвшин тогтсон, хуримтлуулсан туршлага, алдаа оноог онол — түүхийн үүднээс он цагийн хэлхээс дунд нь нягт нямбай шүүн үзэж, орчин үеийн арга зүйг ашиглан уран сайхны шүүмжлэлийн онолын сэтгэлгээний түүхэн хөгжлийн зүй тогтлыг тодорхойлон тогтооход анхаарлаа хандуулсан байна. Шинэ зуун гараад монголын утга зохиол жам зүйнхээ дагуу хөгжиж, утга зохиолын шинэ хөгжил хийгээд өмнөх үеийн их өв санг уламжлалт хийгээд шинэ тутам гарах судалгаа шинжилгээний онол, арга зүйн үүднээс судлан шинжлэх ажил эрчимтэй өрнөж байгаа тул тэрхүү судлал шүүмжлэлийн

ажлын үр дүнг цаг алдалгүй багцлан, оноо, алдааг нь шүүн хэлэлцэх нь чухал юм. Энэхүү судалгааны ажилдаа дээрх асуудлыг баримтжуулах замаар шинэ зууны монголын утга зохиолын онол, шүүмжийн ерөнхий тойм, сэтгэлгээний төлөвшлийг тодруулжээ.

Түлхүүр үгс: XXI зуун, Монгол улсын утга зохиол, утга зохиолын шүүмж, судалгааны арга зүй.

Ишлэл

Булган Урангоо. XXI зууны эхэн үеийн монгол улсын утга зохиолын шүүмжлэлийн судалгаа // Зүүн зүгийн вектор: түүх, нийгэм, улс. 2024:4: 77–86 (монгол хэл дээр)

Удиртгал

Өнө эртний түүхтэй Монгол Улсын урлаг, утга зохиолын түүх яндашгүй баялаг билээ. Энэ баялаг түүхийн нэгээхэн хэсэг, нэн сонирхолтой үе, бичгийн утга зохиолын хэлбэр, төлөв өрнө, дорнын утга зохиолын нөлөөлөлд шинэчлэгдэн хөгжсөн, шинэ шатанд гарсан XXI зууны монгол улсын утга зохиолын түүхийг тоймлох, судлах, төлөв чиг хандлагыг тодорхойлох, уламжлал шинэчлэлийн залгамж халааг тодруулах асуудал чухлаар тавигдах цаг ирсэн байна. “Монголын урлаг, уран зохиол, гоо сайхны сэтгэлгээ түүхэн төлөвшилийнх нь үүднээс авч үзэхэд хөгжлийн нэгэн өвөрмөц үедээ ороод цаг хугацааны хувьд

хориод жилийг нэгэнт өнгөрөөжээ. Өвөрмөц үе гэдгийг урлаг уран сайхны сэтгэлгээ шууд улс төр, үзэл суртлын хараа хяналтгүй болж, агуулга сэдвийн хувьд харьцангуй чөлөөтэй болж аливаа зохиолч уран бүтээлчдийн сэтгэлгээ хаана хүрч, юуг тэмтэрч чаднав түүнийгээ хэлээр илэрхийлэх бодит боломж бий болсон тэр нөхцөл байдлыг л хэлж байна”¹.

XXI зуун түүх болон улираад 20-оод жил болжээ. Энэ хугацаа нь үндэстний урлаг, утга зохиолын түүхэнд богинохон хугацаа мэт боловч хүн төрөлхтний түүхийн хувьд хамгийн хурдацтай, үсрэнгүй хөгжил гарсан, цахимжсан, олон нийтийн сүлжээ дэлхийг бүрхсэн, магадгүй виртуал нийгэм, ертөнц бий болсон, хөгжлийн нэгэн өвөрмөц үеийг туулж байна. Энэ үеийн монголын яруу найраг, хүүрнэл зохиол, жүжгийн зохиол, судлал шүүмж, орчуулгын зохиолын хөгжлийг тоймлон судалсан судалгаа одоогоор бараг үгүй гэж хэлэхэд хилсдэхүй. Энэ ч үүднээс тухайн үеийн нийгмийн байдал тухайн цагийн уран зохиолд хэрхэн нөлөөлөв гэдгийг нарийвчлан тодруулах шаардлага, цаг хугацаа нь ч нэгэнт ирсэн гэж бид үзэж байна.

Монгол улсын орчин үеийн утга зохиолын уран сайхны шүүмжлэлийн түүх, хөгжлийн явц, чиг хандлагыг түүхчлэн судалсан Оросын эрдэмтэн Г.И.Михайловын “Утга зохиолын шүүмжлэл” (1940-1950 оны), профессор Д.Цэндийн “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн тойм” (1929-1964), Оросын эрдэмтэн В.Э.Раднаев “Монголын уран зохиолын шүүмжлэл” (1929-1940), Ц.Мөнх “Монголын шинэ уран зохиолын шүүмжлэлийн түүхэн найруулал” (1921-1940), Д.Галбаатарын “1970-аад оны шүүмжлэлийн хөгжлийн төлөв” (1970-1980), доктор Ц.Магсарын XX зууны монголын утга зохиолын судлал, шинжлэлийг дагнан судалсан “XX зууны монголын утга зохиолын шүүмжлэл” (2009), Бээжингийн Төвийн үндэстний дээд сургуулийн профессор, доктор Ван Мануга “Монголын орчин үеийн уран зохиолын онол шүүмжлэлийн судлал” (2007), С.Байгалсайхан, Д.Цэдэв, А.Мөнх-Оргил, Ш.Баттөр нарын хамтын бүтээл “Монголын шинэ үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн найруулал” (2018) зэрэг хэд хэдэн бүтээл гарсан билээ. Гэвч бидний онцлон буй үеийн буюу 2001-2021 оны утга зохиолын онол, шүүмжийн бүтээлийг нарийвчлан дагнан судалсан зүйл бараг үгүй байна. Тиймээс бид энэхүү хоосон зайг нөхөж Монгол улсын нэн шинэхэн үеийн утга зохиолын онол, шүүмжийн төлөв, цаашдын чиг хандлагыг тодруулахыг хичээлээ. Чингэж утга зохиолын онол, шүүмжлэлийн сэтгэлгээг ямар нэг байдлаар цэгцлэн, шүүмжлэл, судалгааны арга барилыг тодруулах нь утга зохиолын цаашдын хөгжилд чухал хувь нэмэр болох билээ.

Шүүмжлэгч Х.Чойдогжамц “Шинэ зууны шинжлэл судлал” (2018) илтгэлдээ:

- *Суурь судалгааг шинэчилсэн үе (2000–2005)*
- *Шинжлэлт сэтгэлгээ, шүүмж бичлэг идэвхижсэн үе (2005–2010)*
- *Уран сайхны шинжлэл, судлал-урлагийн бүтээлийн түвшинд хөгжиж буй үе (2010-аас өнөөг хүртэл)*²

¹ Байгалсайхан С. 2009. Монголын нэн шинэхэн үеийн уран зохиолын хөгжил, үнэлэмж. “Соёмбо Принтинг”. Улаанбаатар: Яруу утгын тайлал. 1. 7-23 дугаар тал.

² Чойдогжамц Х. 2018. Шинэ зууны шинжлэл судлал. Илтгэл. Улаанбаатар. <https://www.reader.mn/posts/view/226/>

гэж 2000 оноос хойших судлал шүүмжийн чиг хандлагыг хуваан авч үзсэн байна.

1. XXI ЗУУНЫ МОНГОЛ УТГА ЗОХИОЛЫН ШҮҮМЖЛЭГЧДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД

Өнөөдрийн буюу XXI зууны эхэн үеийн Монгол улсын утга зохиолын шүүмжлэгчдийн эгнээний бүрэлдэл гэвэл

- Нэгдүгээрт: Ахмад үеийнхэн
- Хоёрдугаарт: Дунд үеийнхэн
- Гуравт: Залуу үеийнхэн болон шүүмж судлалд эхлэн орж ирж буй залуус,
- Дөрөвт: Монгол утга зохиолыг судлагч гадаадын эрдэмтэд байна.

“Манай судлаачдын бүтээлээс харж байхад монголын уран зохиол судлал шүүмжлэлийн төлөөлөгчдийг 4 юм уу 5 үед хуваан авч үзсэн байх нь элбэг тохиолдож байна”¹. XXI зууны Монгол уран зохиолын шүүмжлэгчдийн эгнээний бүрдлийн талаар доктор Д.Цэвээндорж, А.Мөнх-Оргил нар бичсэн зүйлс байна. Мөн түүнчлэн Улаанбаатарын Их Сургуулийн багш судлаачид “XX зууны монголын уран зохиол” номынхоо 2000-аад оны уран зохиол бүлэгтээ цухас дурдсан зүйлс байна.

XXI зууны монголын утга зохиолын шүүмжлэлийн гол төлөөлөгчид : Д.Галбаатар, С.Байгалсайхан, С.Хөвсгөл, С.Энхбаяр, Ц.Магсар, Б.Батбаяр, Г.Галбаяр, А.Мөнх-Оргил, Б.Мөнхбаяр, П.Батхуяг, Ш.Баттөр, Д.Болормаа, Д.Цэвээндорж, Г.Батсуурь, Х.Чойдогжамц, нарыг нэрлэж болохоор байна.

Улаанбаатарын их сургуулийн багш судлаачдын хэвлүүлсэн “XX зууны монгол уран зохиол”-д “Д.Цэвээндорж, Х.Сүглэгмаа, А.Мөнх-Оргил, Э.Батжавхлан, Ш.Баттөр, Г.Галбаяр, М.Одмандах, С.Амартөвшин, О.Шинэбаяр, Б.Мөнхбаяр, Ж.Ууганбаатар, Т.Баясгалан нар монголын эртний ба орчин үеийн уран зохиолын олон талт асуудлаар судалгаа шинжилгээний ажил хийж байна. 2000-аад оны уран зохиолын ерөнхий чиг хандлага нь бичгийн ба аман зохиолын уламжлалаас бүтээлчээр суралцан дорнын уламжлалт гүн ухааны үндэс ба өрнө дахины орчин цагийн сэтгэлгээг хослуулан реалист ба реалист бус аргаар эрэлхийлж байгаа юм. Энэ нь ч хөгжлийн харьцангуй зөв хандлага мөн бөгөөд гэсэн хэдий ч энэ үеийн уран зохиолын алдаа дутагдал, ололт шинэлэг байдал зэргийг нэгтгэн дүгнэх боломж, бололцоо, цаг хугацааны хувьд одоогоор төдийлөн үгүй байгаа билээ”² гэжээ.

Мөн Улаанбаатарын их сургуулийн багш, судлаачид “Монголын шинэ үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн найруулал”-даа “Энэ салбарт залуу шинэ үе гарч ирж өөр өөрсдийн судлах судлагдахуунаа, сэдэв, он цагийн хязгаар, төрөл зүйлээр ялган судалгаа эрдэм шинжилгээний ажил гүнзгийрэн хөгжиж монгол туургатан, бүс нутгийн хүрээнд өөрсдийн дуу хоолойгоо хүргэж эхэлсэн гэж болно. М.Одмандах, С.Амартөвшин, Г.Галбаяр, О.Шинэбаяр, Д. Цэвээндорж, Б. Мөнхбаяр, А. Мөнх-Оргил, Ш. Баттөр, Э. Батжавхлан, Х.Сүглэгмаа,

¹ Билгүүдэй Г. XX зууны монголын уран зохиолын судлал шүүмжийн чиг хандлага, цаашдын төлөв, чиг хандлага. Улаанбаатар: Хэл зохиол судлал сэтгүүл. 2010. Том. 3(35). Fasc 20. 196.

² Байгалсайхан С., Баттөр Ш., Мөнх-Оргил А., нар. XX зууны монголын уран зохиол. Улаанбаатарын их сургууль. Улаанбаатар. 2017. 529.

Б. Хишигсүх, Г. Нандинбилиг, Ж. Ууганбаатар, П. Батхуяг, Г. Батсуурь, Х. Чойдогжамц, Я. Баяраа нарын олон залуус судлал шүүмжлэлийн залуу халааг аван өөр өөрсдийн үзэл, мэдлэг чадварын хэрээр шинэ монголын яруу тайллын сэтгэлгээний уламжлалыг өвлөн үргэлжлүүлэхийг зорьж явна¹ хэмээн тэмдэглэжээ.

“2001 оноос хойш мэргэжлийн сонгодог зохиол, “бестселлер” гэж яригдах болсон арилжаа, гүйлгээний зохиол хоёрын хооронд “тэмцэл” өрнөсөн нь эдүгээ ч үргэлжилсээр буй бөгөөд судлагч, шүүмжлэгчид нь өөрийн үзэмжээр, нутаг нуга, багш шавийн холбоонд хэт дөвийлгөн магтах, үгүйсгэн гутаах туйлшралын зааг дээр уран сайхны шүүмжлэл өрнөх болов. Уран сайхны шүүмж сонгодог хэлбэрээ гээж ийм “хэрэглээний” шинжтэй болсон нь чөлөөт сэтгэлгээний томоохон ухралт байлаа. Тиймээс “Утга зохиол дахь “Баасан авгай” нар болон бидний үнэт зүйлс” (2008), “Монголын зохиолчид шинэ зуунд юунд найдна вэ?” (2010), “Шүүмжлэл бол доромжлол биш” (2011) гэх мэтишүүмж төвийн сонин хэвлэл, зарим судлагчдын номонд тодорхой зай эзлэх болсон байдаг. Гэхдээ энэхүү 5-р үед утга зохиол судлалд нэгэн шинэ үе төрөн гарсан нь шинжлэх ухааны онол-арга зүйн үндэслэлтэй судалгааны түвшинг ахиулж буйг Г. Галбаяр, А.Мөнх-Оргил нарын залуусын бүтээл, туурвил гэрчилнэ².”

Энэ үеийн шүүмжлэгчдээс Д. Цэдэв, П. Батхуяг, Г. Батсуурь нарыг онцлон дурдах нь зүйтэй болов уу. Учир нь тэд энэ үед уран зохиол судлал, шүүмжлэл чиглэлээр хамгийн идэвхтэй ажилласан байна.

Монгол улсын орчин үеийн утга зохиолыг үндэслэгчдийн бүтээлийг судлах, эх зохиолыг эх бичгийн ухааны үүднээс эмхэтгэн цуглуулах, харьцуулах, хэвлүүлэх ажил шинжлэх ухааны судалгаанд ч уран зохиолын түүхэнд ч нэн чухал бөгөөд судлаач Д.Цэдэв энэхүү нүсэр ажлыг ганцаар нугалж ирсэн байна. Тодруулбал “Д.Нацагдоржийн бүрэн зохиол” I, II, III боть (1996, 2006), “Ц.Дамдинсүрэнгийн бүрэн зохиол” I-V боть (1998, 2001, 2014), “С.Буяннэмэхийн бүрэн зохиол” I-IV боть (Ван Мандугатай хамт, 2008, 2009), “Б.Содномын бүрэн зохиол” I-III боть (2008, 2009) зэрэг нь уран зохиол судлал, эх бичиг судлал, намтар судлалын үнэт өв болсон байна.

Утга зохиол судлаач, шинжлэгч П.Батхуяг нь уран зохиол, урлагийн судлал, шинжлэл, нийтлэлийн чиглэлээр 2005 оноос хойш “МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙН СОЦИОЛОГИ”(2005), “СҮХБААТАРЫН БАТМӨНХ”(2005), “ЯРУУ НАЙРГААР ЯРИЛЦАХУЙ”(2006), “ШИНЭ СЭРЭХҮЙ”(2008), “СТАНДАРТ БУС ШАЛТГААН”(2009), “МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛЫН СТАНДАРТ БУС СЭТГЭЛГЭЭНД ЗОРИУЛАВ”(2010), “ХЭЛБЭРГҮЙ БОДЛОГОШРОЛ”(2011), “ЭСРЭГ ЦАГ-I”(2014), “ЭСРЭГ ЦАГ-II”(2015), “ЭСРЭГ ЦАГ-III”(2016), “ОЧИРБАТЫН ДАШБАЛБАР”(2018) зэрэг ном хэвлүүлсэн байна. Тэр бээр шинэ тутам хэвлэгдэн буй ном бүтээлийг соргоогоор харж, тогтмол үнэлгээ саналаа хэлж, эсээ, нийтлэл, нийтлэл шүүмж

¹ МШҮҮЗСШТН. 2018. Монголын шинэ үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн найруулал. Улаанбаатар Их сургуулийн багш судлаачид. С. Байгалсайхан, А. Мөнх-Оргил, Ш. Батгөр, Э. Батжавхлан нар. Улаанбаатар, 13.

² Цэвээндорж Д., Билгүүдэй Г., нар. 2020. Нэгэн зууны түүхтэй утга зохиол судлал, шүүмжлэлийг товчоолон дүгнэхүй. Улаанбаатар: ХХ зууны монгол утга соёлын өв эмхэтгэл. 2020. 68.

хэлбэрээр илэрхийлэхийн сацуу театр, киноны шүүмж бичлэгт жигд ажиллажээ. Түүний уран сайхны шүүмжийн онцлогийн тухайд профессор С.Энхбаяр: *“П.Батхуяг уран бүтээлийн олон салбарт зэрэг ажилладаг ёстой л “пишущий человек” /homo scriptoris/ билээ. Учир нь тэрээр яруу найрагч, өгүүллэг, тууж, роман гээд үргэлжилсэн үгийн бүх төрлөөр бичдэг, бас хэд хэдэн жүжигтэй өөрөөр хэлбэл үгийн урлагийн бүх төрөл жанраар туурвидаг, дээр нь утга зохиол-уран сайхны шүүмжийн чиглэлээр үнэхээрийн идэвхтэй ажиллаж байгаа /бараг өнөөдөр “амьд” байгаа цорын ганц шүүмжлэгч гээд хэлчихмээр/ харьцангуй залуу хүн билээ”*¹ хэмээн үнэлсэн байна.

Утга зохиол шүүмжлэгч Г.Батсуурь нь уран зохиолын судлал, шүүмжлэлийн чиглэлээр 2010 оноос өдгөө хүртэл “УДИРТГАЛ”, “Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ЯРУУ НАЙРГИЙН АМАН ЗОХИОЛЫН УЛАМЖЛАЛ”(2012), “ДӨРВӨН ЦАГ”-ААС “ЦАГ ХУГАЦАА АМСХИЙХ ЗУУР’ ХҮРТЭЛ”(2012), “УРАН ЗОХИОЛЫН ДЭД АСУУДЛУУД”(2014), “МЕТА УТГА”(2014), “УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙ ЯРИА-I”(2013, ХАМТЫН), “УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙ ЯРИА-II”(2017, ХАМТЫН), “УРАН ЗОХИОЛЫН ТУХАЙ ЯРИА-III”(2018, ХАМТЫН), “Ц.ДАМДИНСҮРЭН: УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ”(2016), “ЕРӨӨЛЧИД БА ШИЗОФРЕНИКУУД(2018)” зэрэг ном хэвлүүлсэн байна. Тэр бээр уран сайхны шүүмжийн нэгэн жигдхэн урсгалыг цочмог ирмүүн бүтээлүүдээрээ хөдөлгөөнд оруулж, ямарваа зохиол бүтээлийн тухай үргэлж шинэ өнцгөөс, гайхам содон тайлал, тайлбарыг дэвшүүлдэг шинжлэлт бичлэгээрээ эрс ялгардаг билээ. Түүний уран бүтээлийн тухай Ц.Магсар “Монголын уран зохиолын шүүмжлэл дэх шинэ үзэгдэл” өгүүлэлдээ: *“Тэдний бичиж байгаа зоригтой, дайчин шүүмжүүдэд аливаа үзэгдэлд тайлбар, тайлал хийх шинэлэг арга зүй, мөн шинэлэг гэмээр онол номын “цэнэг”, сэтгэлгээний цараа, уран зохиолын өргөн мэдлэг мэдрэгдэж байгаа нь шүүмжлэлт сэтгэлгээний хөгжлийн шинэ хандлагыг тодорхойлно гэж үзэх үндэслэл байна”*² гэж үнэлжээ.

*“2010-аад оноос уран сайхны шинжлэл, судлал хөгжлийн дахин шинэ шатанд гарсан нь мэдрэгддэг. Урлагийн бүтээлийн давтагдашгүй үнэт зүйл, яруу туурвилын нууц руу гүнзгийрсэн дотоод шинжлэл, уран сайхны шүүмж-тайлал зүйн шинжлэх ухааны голлох салбар болохын хувьд урлагийн бүтээлийн бие даасан нэгэн хэлбэр болон цэврээр бүтээгдэж, үүрэг хийгээд зорилгодоо үнэнчээр үйлчилж эрчимтэй хөдөлгөөнд орсон гээд олон зүйл ололтыг тэмдэглэж болохоор байна. Урьд жилүүдийн судалгаа, шинжлэлийн бүтээлүүд зөвхөн уран зохиолынхоо хүрээнд бяцхан “эргэлдэж” байсан ахул олон салбар шинжлэх ухаан болоод урлагийн төрөл зүйлүүд хоорондын хавсарсан нийлмэл задлан шинжлэлийн хосолмол ажлууд давамгайл хийгдэх болсон байна”*³.

УРАН ЗОХИОЛ ШИНЖЛЭЛИЙН ОРЧИН ҮЕИЙН АРГУУДЫГ АШИГЛАЖ БУЙ ШИНЭЛЭГ ЧИГ ХАНДЛАГА

Шүүмжлэлийг уран бүтээл талаас нь авч үзэх нэг гол учир шалтгаан бол түүний төрөл зүйлт шинж юм. XXI зуун монгол улсын шүүмжийг, шүүмжлэлийн

¹ Батхуяг П. 2014. Эсрэг цаг. Улаанбаатар. 10.

² Магсар Ц. 2018. Монголын уран зохиолын шүүмжлэл дэх шинэ үзэгдэл. Улаанбаатар. <https://www.facebook.com/groups/269816426460750/posts/1670809453028100/>

³ Мөн тэнд.

төрөл зүйл хөгжсөн уламжлал, уран сайхны шүүмжлэл ба нийтлэлийн ижил төстэй төрөл зүйлүүдийн нийтлэг шинж, европ болон орос утга зохиолд шүүмжлэлийн төрөл зүйлийг ангилдаг зарчим, шүүмжлэлийн бүтээл туурвих зорилго, сэдэл санаа, бүтээлийн агуулга, хэмжээ хэлбэр, зохиомж, найруулга зэргийг харгалзан уран зохиолын шүүмжлэлийг дотор нь шүүмж, шүүмжлэлийн өгүүлэл, нэг сэдэвт зохиол, хөрөг гэсэн үндсэн дөрвөн төрөлд хувааж, төрөл тус бүрдээ хэд хэдэн зүйлийг багтааж ангилж болохоор байна. ХХI зуун гарсаар утга зохиол, урлагийн салбарт нийгмийн хөгжлөө дагаад зах зээлийн хуулиар орших зүй тогтол үйлчлэх болсонтой холбогдон зохиолын борлуулалтыг нэмэгдүүлэх, зохиол бүтээлийн талаар оновчтой эерэг мэдээлэл тараах зорилго бүхий сурталчилгаа шүүмж, охор шүүмж гэх мэт шинэ төрөл зүйл дэлгэрэх хандлага бүрдэж байгааг бас дурдууштай.

Шинэ зуунд уран сайхны шүүмжлэл нь шүүмж, тойм, тайлбар өгүүлэл, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, ганц сэдэвт зохиол, хурц шүүмжлэл зэрэг бичлэгийн олон төрөл, хэлбэрүүдийнхээ онцлогийг хадгалахын зэрэгцээ шүүмжийн төрлийн доторх зүйлүүдийн ялгарал багасаж, **төрөл зүйлүүдийн нийлэгжих** /*genre hybridization*/ үзэгдэл ажиглагдаж байна. Тодруулбал, зарим нэгэн шүүмжлэгчийн уран сайхны үзэл баримтлал, хувийн байр суурь, бичлэгийн онцлогоос шалтгаалж, шүүмжлэлийн уламжлалт хэлбэрүүд нэг нэгэндээ уусах хандлага зарим тохиолдолд ажиглагдаж байна. Тэр ч бүү хэл зарим шинэ төрлийн шүүмжийн хэлбэр бий болсон байна. Тухайлбал, Д.Цэвээндорж дан асуулт хэлбэрээр бүтсэн “Асуулт дүүрэн зохиол аль нь вэ?” хэмээх “асуулт шүүмж”-ийг зохиолч Д.Норовт бичсэн байна. Энэ шүүмж нь уламжлалт захидал шүүмжийн хэлбэрийг хадгалахын зэрэгцээ асуудал дэвшүүлсэн өгүүллийн шинжтэй байна. Энэ ганцхан жишээнээс бид шүүмжийн төрөл зүйлүүд нийлэгжих үзэгдлийг харж болох юм. “Асуулт шүүмж” (Critique questions) хэмээх төрөл (not the critical thinking question) уран сайхны шүүмжлэлд буюу дэлхийн утга зохиолын нэр томъёо, онолын бүтээлүүдэд үгүй ч “захидал шүүмж” (Criticism letter)-ийн нэгэн шинэ хэлбэр ийн үүссэн байна.

Шинэ зууны утга зохиол судлал шүүмжлэлийн төрөл зүйлийн хувьсалд онцлон дурдах ёстой нэгэн зүйл нь эсээ шүүмжийн хэлбэршил юм. Үгийн урлагийн төрлүүдээс “би”-гээ илэрхийлэх чөлөөт зохиомжтой зохиолын нэгэн өвөрмөц төрөл зүйл бол эсээ юм. Эсээ нь шинэ сонирхолтой санаа бодол, тодорхойллыг уншигчдад санал болгож, түүх, гүн ухаан, намтар судлал, уран зохиолын нийтлэл, шүүмжлэл, шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол хэлбэрээр бичигддэг. Уран зохиол, сэтгүүл зүй, шинжлэх ухааны бүтээлийн бичлэгийн арга найруулгыг нэгтгэсэн шинжтэйгээрээ онцлог. Бичлэгийн хэв маяг нь товч уран, дүрслэг шинжтэйгээс гадны ярианы аялга, үгсийн сан, зорилгоороо ялгардаг.

Шинэ зууны утга зохиол судлалд эсээ хэлбэрийн шүүмжийг Г.Батсуурь, Х.Чойдогжамц, П.Батхуяг, Б.Алтанхуяг, У.Бямбаян нарын олон шүүмжлэгчид бичиж байна. Тухайлбал, Х.Чойдогжамц “Тсинаканы зүүд” эсээ шүүмждээ алдарт зохиолч Х.Л.Борхесын “Боогийн бичээс” өгүүллэгийг шинжлэх явцдаа бурхны тухай бодол, эргэцүүлээ тус шүүмждээ бичсэн байна. Тодруулбал, “Цаг болж, нөхцөл бүрэлдсэний улмаас санаа сэтгэл, махбодийн аль аль нь үүсэх учир бие нь өөрийн мөн чанаргүй билээ. Бие бээр нөхцөл нь бүрэлдэхэд буй болсон тул мөнхийн чанартай бус юм. Хэрэв бие махбод өөрийн мөн чанартай байсан бол

өөрөө ямар байхыг хүснэ, яг тийм болж чадна...Үүнтэй нэгэн адил санаа сэтгэл өөрийн мөн чанаргүй. Цаг нь ирж, нөхцөл бүрэлдэхэд, санаа сэтгэл буй болох тул хувирамтгай чанартай..." гэх үгс ажгуу. Жинхэнээсээ сэрсэн л Тсинаканд хамгийн сайхан "зүүд" агаад бурханы нууц бичээс байх эсэх, түүний далд агуулга юун тухай болох нь одоо нэгэнт сонирхолгүй танин мэдэхүй болон хувирсан байлаа. Харин өөрийгөө бурхны нэгэн бичээс болох Тсинакан, хананы нөгөө талд буй цоохор ирвэсийг Чилам балам гэдгийг тодоос тод мэдэж авсан нь юутай ч зүйрлэн өгүүлэггүй баяр бахдал байв шүү" гэхчлэн бичсэн байна.

П.Батхуяг нь шинэ зууны Монгол улсын утга зохиол, театрын урлаг, дэлгэцийн уран бүтээлийг судлагч, шүүмжлэгч томоохон дуу хоолой байлаа. Тэрбээр монголын шүүмж бичлэгт эсээ хэлбэржилтийг бий болгосон байна. Зохиолч, яруу найрагч, судлаач П.Батхуяг нь уран сайхны бүтээлийн олон төрлөөр бичихийн сацуу эрдэм шинжилгээ, судлал шүүмжлэлийн чиглэлээр жигд хослуулан туурвидаг уран бүтээлч билээ. Утга зохиол, соёл урлаг судлал, нийтлэл, шинжлэл, сурган хүмүүжүүлэхүйн өргөн салбарт ажилладаг энэхүү урлал, сэтгэлгээний онцгой арга барилыг мөн л олон талт хэв шинжийг тээсэн эсээ бичвэрүүдэд шингэснийг харж болдог.

Тэр бээр эсээ бүтээл бүрдээ баримт туршлага, өөрийн эргэцүүлэл, уран сайхан, гүн ухаан, нотолгоо дүгнэлт, яруу хүүрнэлийн уянгын өнгө аясыг чөлөөтэй цогцлоон оршоож чаддаг онцлогтой. Эрдэмтэн зохиолч уран бүтээлчийн хувьд үгээс үг таньж, санаанаас санаа ургуулж, баримтаас баримтад шилжүүлэн, эргэцүүлээс эргэцүүлэл рүү хөврүүлэх нийтгэх сэтгэлгээний хурд нь П.Батхуягийн бичсэн эсээ гэж ялгарах хүчин зүйл болдог. Хамгийн богино эсээнээс ч энэ давуу шинж чанарын давтагдашгүй тогтмол танигддаг билээ.

Монгол улсын утга зохиол судлалд сүүлийн жилүүдэд өргөн ашиглаж хэвшсэн түүхэн арга, түүхэн харьцуулсан арга, хэлний ба эх бичгийн судалгааны болон задлан шинжлэх аргаас гадна аксиоматик арга (индукци-дедукци), хэв шинжийн (типологический метод), хэлбэрийн (формальный метод), социологийн судалгааны арга, орчин үед өргөн хэрэглэж буй сэтгэл зүйн задлагийн арга (психоанализ), бүтэц үүргийн болон системийн арга, гарваль зүй цаашилбал философийн герменевтик (тайлал зүй) болон түүний таамаглалт бүлэглэл хийгээд дивнаци, төлөгчлөн судлах аргуудыг судалгаанд ашиглах өргөн боломж нээгдсэн байна.

Тухайлбал, “Домог зүйн шинжлэл” (Myth criticism)-ийн аргыг ашигласан С.Дуламын “Харь гаралтай үлгэр, домгийн идээшихэд архетипийн нөлөө” (2011) өгүүлэл, Г.Батсуурийн “Саглагар мод” (2016), “Ендэр мөнгөн хуур” (2016) зэрэг шүүмж хэвлэгджээ. “Сэтгэхүйн үзэгдлийг тайлах шинжлэл” (Phenomenology criticism)-ийн аргыг ашигласан Ч.Билигсайханы “Өлзийтөгсийг уншаад өнөөгийн яруу найргийг бодохул...” (2002), Б.Алтанхуягийн “Бодлоор туулсан амьдрал ба “Морин уруул”-ын феноменологи” (2016) зэрэг шүүмж гарсан байна.

“Хэлбэр зүйн сургууль” (Formalist study)-ийн аргаар С.Амантөвшины “Галсансүхийн хэлбэрдсэн сэтгэлийн галбар”-ыг шинжлэхүй” шүүмж хэвлэгджээ. “Шинэ шинжлэл” (New criticism)-ийн аргаар Д.Галбаатарын “Хоёроос хасах нь нэг, тэнцэх нь тэг буюу харанхуйд харагдахгүй” буюу таван бүлэгт абсурд философийн жүжгийн тухайд”, Ш.Баттөрийн “Яруу найраг гэж юу вэ” Б.Эрдэнэсолонгын “Зун шиг” түүврийн жишээн дээр” зэрэг шүүмж гарчээ.

“Бүтэц зүйн онол” (Structuralism)-оор Л.С.Дампилова “Б.Галсансүхийн сэтгэл хөдлөлийн өнгө аястай яруу найраг” (2010) зэрэг шүүмж хэвлэгджээ. “Бүтцийг үгүйсгэх онол” (Deconstructivism)-оор Ч.Билигсайханы “Овоо босгохгүй бол шаазгай юун дээр суух билээ” (2001), П.Батхуягын “Трегор Замза ба эрхвээхэй” (2016) зэрэг шүүмж гарчээ.

“Тайлал зүйн онол” (Hermeneutic)-оор Ж.Отгонбаярын “Харанхуй хад” өгүүллэгийн бэлгэдэл утгын тухай” (2007), Г.Батсуурийн “Донровын намдаг юу гэж улив”? /хувилбар-1/ (2011), “Донровын намдаг юу гэж улив”?/хувилбар-2/(2012), Х.Чойдогжамцын “Яруу найрагч О.Дашбалбарын нэргүй шүлгийн нэгэн мөрийг бэдрэхүй” (2013), “Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” туужийн “экзистенци”-ийг тайлахуйд” (2013) зэрэг өгүүлэл хэвлэгдсэн байна. “Зааварчлах шинжлэл” (Recertive criticism)-ээр Х.Чойдогжамцын “Нүдний шилэнд үлдсэн хотын үлгэрүүд” (2014) шүүмж гарчээ.

“Сэтгэц задлал” (Psychoanalytic criticism)-аар Г. Батсуурийн “Б. Лхагвасүрэнгийн садизм”, “Эмэгтэйчүүдийн уран зохиол хийгээд дүрслэхүй, тайлбарлахуй” (2017), Ж. Отгонсүрэнгийн “Зүүдний онол ба Шүгдэн роман дахь зүүдний өгүүлэмж” (2013), С. Амартүвшиний “Монголын нууц товчоо”-ноос муу бүтээл төрөх ёсгүй” Х. Чойдогжамцын “Миний мэдэх Зигмунд Фройд (“Эдипийн комплекс”-оос “Анти-Эдип” хүртэлх нөхөрлөл минь)” (2014) зэрэг шүүмж хэвлэгдсэн байна. Шизо задлал (Schizoanalytic)-аар Г. Батсуурийн “Харанхуй хад”-аас үүдсэн шизоанализмын таталбар” (2017) гэх шүүмж гарчээ.

“Өгүүлэмжийн онол” (Narratology)-оор С.Энхбаярын “Нэн шинэхэн үеийн монголын уран зохиол дахь үргэлжилсэн үгийн хөгжлийн төлөв, чиг хандлага” (2005) шүүмж хэвлэгджээ. “Тэмдэг зүйн онол” (Semiotic)-оор Б.Пүрэв-Очирын “Аргалчин ээжийн бичээч хөвгүүд, Аргалын цэнхэр галыг тойроод-1” судалбар эсээ” (2005) шүүмж гарчээ.

Бидний онцлон судлан буй үе (2001–2021)-ийн төгсгөл үед хэвлэгдсэн У. Бямбаямын “Цаг хугацаа хэлнэ” (2018), Б. Алтанхуягийн “Уншихуйд автахуй” (2020) зэрэг утга зохиолын шүүмж судлалын ном нь утга зохиолын сонгодог судалгаа, шүүмж гэхээсээ илүүтэй бүтээлч уншлагын туршлагыг дэлгэн харуулсан уншигч төвт судалгааны жишээнүүд юм. Б.Алтанхуягийн “Уншихуйд автахуй” шүүмжийн ном нь Монголын зохиолчдын эвлэлээс утга зохиолын шүүмжийн төрөлд “Алтан өд” шагнал хүртсэн байна.

Уншигч төвт судалгааны үед санаа нь уншигчаар бүтээгдэж байдаг. Эдгээр бичвэр угаас өргөлт өгч байгаа шилжилтээрээ ялгарна. Зарим сэхээлэг уншигчийн юм уу, мэргэжилтний хийсэн тайлал тайлбарууд бичвэрийн тоглолтод тулгуурладаг бол зарим нь хувийн туршлагад, олонх нь нийгмийн юм уу, сэтгэл зүйн асуудалд төвлөрдөг. Номын хуудсыг анх эргүүлээд “зохиогч төвтэй” магтаалчлал мэт харагдах ч номыг уншиж эхлэхэд жинхэнэ “уншигч төвтэй” бичвэр рүү шунган орж, өөр өөр цаг үеийн, өөр өөр орны зохиолчдын туршлага руу эдгээр номын зохиогчийн сонголт, мэдрэмжээр дамжин хөтлөгдөх төдийгүй номын зохиогчтой ч өөрийн сэтгэгдлээ хуваалцмаар санагдах болно.

Б.Алтанхуяг “Уншихуйд автахуй” номдоо гадаад, дотоодын 40 орчим зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг задлан шинжсэнээ багтаажээ. Хорхэ Луис Борхэс, Владимир Набоков нарын утга зохиолын суутнуудаас гадна өдгөө бичиж туурвиж байгаа монгол зохиолч, яруу найрагчдыг багтаасан байна. Тус номын редактор энэхүү бүтээлийг “Сонголттой уншигч болохыг хүссэн хүний

сонгох эхний ном”¹ хэмээн тодорхойлсон байна. Аливаа зохиол хоёр хүнд яг ижил уншигдана гэж үгүй биз ээ. Хэн ч гэсэн зохиол уншихдаа өөрийн туулсан амьдрал, туршлага, сэрэл мэдрэмждээ тулгуурлан эргэцүүлэхийг эргэцүүлж, гээхийг гээж, шингээхийг нь шингээж уншдаг. Бас, хүний болоод амьдралын мөн чанар юу юм бэ гэх мөнхийн асуултын хариултыг дор бүрнээ эрж байдаг. Улмаар зохиол бүтээлээр дамжуулан өөрийнхөө дотроос тэрхүү хариултыг олж харахыг хичээнэ. Б.Алтанхуяг яг л ийм эрэл хайгуулд уншигчийг хөтлөх болно.

Харин У.Бямбаямын “Цаг хугацаа хэлнэ” бол уран зохиолын эсээ хэлбэрээр бичигдсэн шүүмжийн ном юм. Тус номд Итало Калвино, Жозе Сарамаго, Жумпа Лахири, Ян Лианкэ, Зэди Смит зэрэг дэлхийн болон монголын уран зохиолын орчин үе, нэн шинэ үеийн 43 төлөөлөгчийн уран бүтээл, бичлэгийн арга барил, сэтгэлгээний онцлог, хэл хэллэг, зохиолын тойм зэргийг багтаан орчин цагийн шүүмж судлалын салбарын шинэлэг бичлэгийн хэлбэр болох уран зохиолын эсээ (literary essay), тайлал эсээ (analytic essay) байдлаар бичжээ. Тус номын талаар МУИС-ийн багш, утга зохиол судлаач Г.Нандинбилиг “Энэ ном бичвэрийн судалгаа гэхээсээ бүтээлч уншлагын туршлагыг дэлгэн харуулсан жинхэнэ уншигч төвт бичвэр. “Уншихуй”, “Оришихуй”, “Мэдрэхуй”, “Нээхуй”, “Санахуй” гэсэн таван бүлэгтэй тус номын доторх бичвэрийн гарчиг их онцгой”² гэжээ. Энэ мэтчилэн XXI зууны шүүмж судлалд “Уншигч төвт” судалгааны чиг хандлага төлөвшиж байна.

Дүгнэлт

Шинэ үеийн утга зохиол-уран сайхны шүүмжлэл нь өөрийнхөө мөн чанараар ихээхэн утилитарист (хэрэглээний) шинжтэй шүүмжлэл болсон хэдий ч бүхэлд нь аваад үзвэл нийгмийн амьдралыг задлан шинжилж түүнд идэвхтэй субъект болж оролцох гэсэн уран сайхны шүүмжлэлийн эрмэлзэл тэмүүлэл нь уншигч олон түмнийг цаашлаад нийгмийг соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн онцгой ач холбогдолтой өвөрмөц үйл ажиллагаа болж байна. Энэ ч чанараараа уран сайхны шүүмжлэл нь орчин цагийн Монгол улсын утга зохиол болон уран бүтээлчдийн хэд хэдэн үед гүн ухаан гоо зүйн үзэл баримтлалын үндсэн чиг баримжаа болж, уран сайхны туурвил зүйн өсөлт хөгжилтөд онцгой бүтээгч үүрэг гүйцэтгэж байгаа юм.

XXI зуунд монгол улсын утга зохиол судлаач шүүмжлэгчид өрнө дахинд дэлгэрч буй утга зохиол шинжлэлийн орчин үеийн аргуудыг ашиглаж буй шинэлэг чиг хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, “Домог зүйн шинжлэл”, “Сэтгэхүйн үзэгдлийг тайлах шинжлэл”, “Хэлбэр зүйн сургууль”, “Шинэ шинжлэл”, “Бүтэц зүйн онол”, “Бүтцийг үгүйсгэх онол”, “Тайлал зүйн онол”, “Зааварчлах шинжлэл”, “Шизозадлал”, “Өгүүлэмжийн онол”, “Тэмдэг зүйн онол” зэрэг орчин цагийн утга зохиол шинжлэлийн аргыг ашиглаж бичсэн олон шүүмж бичигджээ. Түүнчлэн XXI зууны шүүмж судлалд “Уншигч төвт” судалгааны чиг хандлага төлөвшиж байна.

Ном зүй

1. Алтанхуяг Б. *Уншихуйд автахуй*. Улаанбаатар.2020. 200 х.

¹ Алтанхуяг Б. *Уншихуйд автахуй*. Улаанбаатар, 2020. 3.

² Бямбаям У. *Цаг хугацаа хэлнэ*. Улаанбаатар, 2018. 5.

2. Байгалсайхан С. *Монголын нэн шинэхэн үеийн уран зохиолын хөгжил, үнэлэмж*. “Соёмбо Принтинг”. Улаанбаатар: Яруу утгын тайлал. 2009. 7-23 дугаар тал.
3. Батхуяг П. *Эсрэг цаг*. Улаанбаатар. 2014. 207 х.
4. Билгүүдэй Г. *XX зууны монголын уран зохиолын судлал шүүмжийн чиг хандлага, цаашдын төлөв, чиг хандлага*. Улаанбаатар: Хэл зохиол судлал сэтгүүл. 2010. Том. 3 (35). Fasc 20. 191-198 дугаар тал.
5. Бямбаян, *Цаг хугацаа хэлнэ*. Улаанбаатар., 2018. 301 х.
6. Магсар Ц. *Монголын уран зохиолын шүүмжлэл дэх шинэ үзэгдэл*. Улаанбаатар. 2018. <https://www.facebook.com/groups/269816426460750/posts/1670809453028100/>
7. Мөнх-Оргил А. *Уран зохиолын онол, түүхийн судалгаа*. Улаанбаатар: Утга зохиол, урлаг сонин. 2022. № 021/2667
8. МШҮҮЗСШТН. *Монголын шинэ үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн түүхэн найруулал*. Улаанбаатар Их сургуулийн багш судлаачид. С.Байгалсайхан, А.Мөнх-Оргил, Ш.Баттөр, Э.Батжавхлан нар. Улаанбаатар, 2018. 324 х.
9. Байгалсайхан С., Баттөр Ш., Мөнх-Оргил нар А. *XX зууны монголын уран зохиол*. Улаанбаатарын их сургууль. Улаанбаатар, 2017. 529 х.
10. Цэвээндорж Д., Билгүүдэй Г., Хишигсүх Б., Болормаа Д. *Нэгэн зууны түүхтэй утга зохиол судлал, шүүмжлэлийг товчоолон дүгнэхүй*. Улаанбаатар: XX зууны монгол утга соёлын өв эмхэтгэл. 2020. 44-74 дүгээр тал.
11. Чойдогжамц Х. *Шинэ зууны шинжлэл судлал*. Илтгэл. Улаанбаатар. 2018. URL: <https://www.reader.mn/posts/view/226/>

Нийтлэлийг 2024 оны 11 сарын 10 өдөр редактор хүлээн авсан; хянан үзээд 2024 оны 12 сарын 9 өдөр баталсан; 2024 12 сарын 12 өдөр хэвлүүлэхээр хүлээн зөвшөөрсөн.

The Development of Literature and Literary Criticism in Mongolia in the Early 21st Century

Bulgan Urangoo

Doctoral Student

Institute for Mongolian Studies
of the Inner Mongolia University
urangoo1902@gmail.com

Abstract. The article provides a brief overview of literary studies and criticism from 2001 to 2021. The history of literary criticism in Mongolia is analyzed, with particular attention given to its developmental features, various genres, and lessons learned from past mistakes and achievements, utilizing both historical and theoretical approaches. Additionally, it is noted that artistic criticism has grown over time. Since the 2000s, Mongolian literature has evolved based on its unique characteristics and the accomplishments of earlier periods. The study characterizes the development of research and analyzes new theoretical approaches, emphasizing the importance of learning from past errors. The main goal of the article is to present a concise evolution of Mongolian literary theory and criticism in this new era, identifying new trends and development prospects.

Keywords: Mongolian literature of the 21st century, literary criticism, research methodology.

For citation

Urangoo Bulgan. The Development of Literature and Literary Criticism in Mongolia in the Early 21st Century. *Oriental Vector: History, Society, State*. 2024; 4: 77–86 (In Mong)

The article was submitted 10.11.2024; approved after review 09.12.2024; accepted for publication 12.12.2024.